



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/778

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн физик, биологи, бага боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх 1, 2 дугаар шатны сургалт зохион байгуулахад 10000000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Зардалд зарцуулагдах 10000000 төгрөг /Арван сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/03 тоот тогтоолын 5 дугаар хавсарлтын 5.9 баруун бүсийн математикийн олимпиад зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/-д тус тус зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 25-ны өдрийн
А/778 дугаар захирамжийн хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨСӨВ

ДД	Сургалтанд оролцогчид	Багшийн тоо	Шаардлагатай зардлын хэмжээ	Тайлбар
1	Бага ангийн багш	110	3247600	
2	Биологийн багш нарын сургалт 1, 2 дугаар шат	60	2940000	Сургалтыг 2 үе шаттай зохион байгуулсан
3	Физикийн багш нарын сургалт 1, 2 дугаар шат	210	3812400	Сургалтыг 2 үе шаттай зохион байгуулсан
	Нийт дүн		10000000	

-oOo-